



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/991

Мандалговь

“Брайль цонх” сургалтад шаардагдах
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10, аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зорилт 1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Харааны бэрхшээлтэй иргэд, бага ангийн болон “Насан туршийн боловсролын төв”-ийн багш нарын “Брайль цонх” сургалтад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтад шаардагдах төсөв 4,230,000 (Дөрвөн сая хоёр зуун гучин мянган) төгрөгийг аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

482310060

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын
11-ны өдрийн 67 дугаар захирамжийн хавсралт



БРАЙЛЬ БИЧГИЙН 14 ХОНОГИЙН
СУРГАЛТЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Хоног	Хүний тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
1	Багшийн урамшуулал	14	1	50,000	700,000
2	Туслах багшийн урамшуулал	14	1	30,000	420,000
3	Багшийн хоол	14	1	35,000	490,000
4	Сурагчдын хоол	14	15	12,000	2,520,000
5	Бусад зардал			100,000	100,000
	Нийт дүн				4,230,000